



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Орхон-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 14 нэрийн, нийт 70,006,961.00 (далан сая зургаан мянга есөн зуун жаран нэгэн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Орхон-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Батзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, эргэлтийн хөрөнгөд сэлбэг материалаар орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2021 оны 10  
дугаар сарын 19-ний өдрийн .....  
дугаар тогтоолын хавсралт

**"Орхон-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах  
хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын, Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөг)
1	Мерседес бенк Е-200 маркийн суудлын автомашин	1999/2014	1	641,350.00	641,350.00
2	Жинбей маркийн 46-42 ОРО улсын дугаартай, микробавтобус, Арлын дугаар LSYHBAAA87K040643	2007/2007	1	1,399,791.00	1,399,791.00
3	Тата маркийн 57-26 УБ улсын дугаартай, трактор, Арлын дугаар 315СУ161	2003/2008	1	56,295,000.00	56,295,000.00
4	Будгийн компрессор	2015	1	116,440.00	116,440.00
5	Гар багаж	2009	1	2,650,000.00	2,650,000.00
6	Скайнер	2015	1	107,380.00	107,380.00
7	Компакт индүү	2008	1	1,585,000.00	1,585,000.00
8	Гар утас /мастер/	2018	3	479,000.00	1,437,000.00
9	Буйдан	2015	1	1,550,000.00	1,550,000.00
10	Бялдаржуулах ком	2009	1	260,000.00	260,000.00
11	Гүйлтийн зам	2009	1	1,600,000.00	1,600,000.00
12	Унадаг дугуй	2009	1	340,000.00	340,000.00
13	Станц	2015	1	1,575,000.00	1,575,000.00
14	Ус цэвэршүүлэгч	2014	1	450,000.00	450,000.00
			16		70,006,961.00
	<b>ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН</b>		16 (арван зургаа)		70,006,961.00 (далан сая зургаан мянга есөн зуун жаран нэгэн)